



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ДЭРГЭДЭХ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ
АГЕНТЛАГ ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 07 сарын 20-ны өдөр

Дугаар А/04

Булган

Эх, хүүхдэд үзүүлэх эмнэлгийн тусламж
үйлчилгээний чанар, хүртээмжийг
сайжруулах тухай

Монгол Улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 67 дугаар зүйл, “Эрүүл мэндийн тухай” хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.4, 12.1.5, “Хувь хүний нууцын тухай” хуулийн 5 дугаар зүйлийн 5.3, 5.4 дэх заалтууд, Монгол улсын Засгийн газрын 2017 оны 78 дугаар тогтоол (Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд үндэсний хөтөлбөр)-ийн 3.2.1.1, 3.2.1.3 дахь заал, ЭМС-ын 2016 оны А/204 дүгээр тушаал (Эх, хүүхдийн өвчлөл, эндэгдлийг бууруулах тухай), 2020 оны А/318 дугаар тушаал (Жирэмсэн, төрөх, төрсний дараах үеийн тусламж үйлчилгээг сайжруулах тухай)-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эх, хүүхдэд үзүүлж буй анхан шатны болон нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжид үнэлгээ өгч, мэргэжил арга зүйгээр ханган ажиллах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, Ажиллах журмыг хоёрдугаар, Өрх, сумдын Эрүүл мэндийн байгууллагуудыг хариуцан ажиллах мэргэжилтнүүд, Эх барих эмэгтэйчүүдийн эмч нарын хуваарийг гуравдугаар, өрх, сумдын ЭМБ-уудыг хариуцан ажиллах хүүхдийн эмч нарын хуваарийг дөрөвдүгээр, Эрүүл мэндийн байгууллагуудад эх, хүүхдийн тусламж үйлчилгээний чиглэлээр дэмжлэгт хяналт хийх “Хяналтын хуудас”-уудыг тавдугаар хавсралтаар баталсугай.


2. Тушаалыг хэрэгжүүлэн ажиллах талаар удирдлага, зохион байгуулалтын шуурхай арга хэмжээ авч эх, хүүхдийн тусламж үйлчилгээний бэлэн байдлыг ханган, тушаалын хавсралтаар батлагдсан “Хяналтын хуудас”-уудаар өөрийн байгууллагад улирал тутам үнэлгээ хийж, төрийн албан хаагчдад хариуцлага, урамшуулал тооцон ажиллахыг нийт Эрүүл мэндийн байгууллагуудын дарга нарт, Эрүүл мэндийн байгууллагуудыг мэргэжил арга зүй, эргэн мэдээллээр ханган ажиллахыг ажлын хэсгийн ахлагчид үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэнд онцгой хяналт тавьж, Эрүүл мэндийн байгууллагуудын жилийн эцсийн ажил дүгнэх үзүүлэлтэд, ажлын үр дүнг тооцон ажиллахыг ажлын хэсгийн ахлагчид, Мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг ханган ажиллахыг Эрүүл мэндийн статистик мэдээ мэдээлэл хариуцсан мэргэжилтэнд, Ажлын хэсгийн үйл ажиллагаанд дотоодын хяналт хийж, төрийн албан хаагчдын ажил дүгнэх шалгуур үзүүлэлтэнд үр дүнг тооцон ажиллахыг “Байгууллагын дотоод хяналтын баг”-ийн ахлагчид үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн газрын даргын 2019 оны А/43 дугаар тушаалыг хүчингүй болгосугай.

ДАРГА  С.НАРАНТУЯА

Эрүүл мэндийн газрын даргын 2022 оны
01 дугаар сарын 20-ны өдрийн А/04
дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч:

Эмнэлгийн тусламж, үйлчилгээний хэлтсийн дарга

Гишүүд:

ЭМГ-ын Эрүүл мэндийн статистик, мэдээ мэдээлэл хариуцсан
мэргэжилтэн

ЭМГ-ын Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарын асуудал
хариуцсан мэргэжилтэн

ЭМГ-ын Сувилахуйн болон яаралтай тусламж үйлчилгээ хариуцсан
мэргэжилтэн

ЭМГ-ын Эмнэлгийн тусламж үйлчилгээний халдвар хамгаалал
хариуцсан мэргэжилтэн

ЭМГ-ын Сум, өрхийн ЭМТ-ийн тусламж үйлчилгээ, сэтгэцийн эрүүл
мэндийн асуудал хариуцсан мэргэжилтэн

Аймгийн НЭ-ийн Чанар албаны дарга

Аймгийн НЭ-ийн Эх барих, эмэгтэйчүүдийн ерөнхий мэргэжилтэн,
зөвлөх их эмч

Аймгийн НЭ-ийн Хүүхдийн ерөнхий мэргэжилтэн, зөвлөх их эмч

Аймгийн НЭ-ийн Нярайн их эмч

Нарийн бичгийн дарга:

Эх барих эмэгтэйчүүд, нөхөн үржихүй, хүүхдийн тусламж үйлчилгээ
хариуцсан мэргэжилтэн

- ЭШХ, БЗДХ-аас урьдчилан сэргийлэх талаар мэдээлэл, сургалт сурталчилгаа зохион байгуулж, эмч, эмнэлгийн мэргэжилтний мэдлэг, боловсролыг дээшлүүлэх

4. Аймгийн НЭ-ийн эх, барих эмэгтэйчүүдийн ерөнхий мэргэжилтэн, зөвлөх эмч

- Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй Эрүүл мэндийн байгууллагуудыг эх барихын тусламж үйлчилгээний чиглэлээр мэргэжил арга зүйгээр ханган, мэргэжлийн зөвлөгөө өгөх

- Сум, өрхийн ЭМБ-уудын эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд эх барих эмэгтэйчүүдийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах талаар ажлын байрны солилцох дадлага, сургалт зохион байгуулах

- Эх, хүүхдийн эндэгдэл, эхийн ноцтой хүндрэл гарсан тохиолдол бүрийг магадлан хэлэлцэж, дүгнэлт гарган, цаашид эрсдэл, хүндрэл гарахаас урьдчилан сэргийлэх талаар Эрүүл мэндийн байгууллагуудыг мэргэжил арга зүйгээр хангаж ажиллах

- Эх, хүүхдийн тусламж үйлчилгээний чиглэлээр Эрүүл мэндийн газрын холбогдох мэргэжилтнүүдтэй хамтран сургалт зохион байгуулж, үр дүнг тооцох

5. Хүүхдийн ерөнхий мэргэжилтэн, зөвлөх эмч

- Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй Эрүүл мэндийн байгууллагуудыг хүүхдийн тусламж үйлчилгээний чиглэлээр мэргэжил арга зүйгээр ханган, мэргэжлийн зөвлөгөө өгөх

- 0-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл гарсан тохиолдол бүрийг магадлан хэлэлцэж, эндэгдлийн шалтгааныг тогтоож дүгнэлт гаргах, эндэгдэл гарахаас урьдчилан сэргийлэх талаар холбогдох мэргэжилтнүүдтэй хамтран ажиллах

- Хүүхдэд зонхилон тохиолдох өвчлөлийн байдалд дүгнэлт хийж, өвчлөл, эндэгдлийг бууруулах талаар мэргэжлийн зөвлөгөө өгч, Эрүүл мэндийн байгууллагуудтай хамтран ажиллах

- Өрх, сумын Эрүүл мэндийн байгууллагуудын “ХӨЦМ”-ийн хэрэгжилтэнд үнэлгээ өгч, мэргэжил арга зүйгээр ханган ажиллах

- Хүүхдийн эндэгдэл гарсан тохиолдол бүрт эмгэг судлалын хурлыг зохион байгуулахад холбогдох эмч, мэргэжилтнүүдтэй хамтран ажиллаж, эндэгдэл гаргасан сумдын Эрүүл мэндийн байгууллагуудын үдирдлагуудыг оролцуулах

6. Ажлын хэсгийн нарийн бичгийн даргын чиг үүрэг

- Эх, хүүхдийн тусламж үйлчилгээний үйл ажиллагааг жил, улирлаар төлөвлөн, тухайн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт үр дүнг тооцон, дараа жилийн төлөвлөгөөг ажлын хэсгийн хурлаар хэлэлцүүлж батлуулах

- Эх, хүүхдийн тусламж үйлчилгээний чиглэлээр мөрдөгдөж буй эрх зүйн актуудын хэрэгжилтэнд салбарын дотоодын хяналт хийж, мэргэжил арга зүйгээр ханган, зөвлөмж хүргүүлэн хэрэгжилт үр дүнг тооцон ажиллах

- Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг сургалтанд үе шаттай хамруулах ажлыг зохион байгуулах

- Сар бүрийн эрүүл мэндийн статистик мэдээгээр эх, хүүхдийн өвчлөл эндэгдэл өндөртэй байгаа Эрүүл мэндийн байгууллагуудын талаарх мэдээллийг Эрүүл мэндийн газрын даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж хэвшүүлэх

- Эх, хүүхдийн эндэгдэл, эхийн ноцтой хүндрэлийг магадлан хэлэлцэж хурлаас гарсан хурлын дүгнэлтийг ЭХЭМҮТ-ийн Тандалт судалгааны албанд хүргүүлэх
 - Ажлын хэсгийн хурлаас гарсан шийдвэр, зөвлөмжийг удирдлагад танилцуулан удирдлагын шийдвэрийг баримтлан эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлэн, хяналт тавих
 - Ажлын хэсгийн хурлын бэлтгэл ажлыг хангах
 - Ажлын хэсгийн хурлын тэмдэглэлийг хөтлөх
 - Ажлын хэсгийн үйл ажиллагаатай холбоотой эрх зүйн акт, бичиг баримт бүрдүүлэх, хөтлөх

Эрүүл мэндийн газрын даргын 2022 оны
01 дугаар сарын 20 -ны өдрийн А/04
 дугаар тушаалын гуравдугаар хавсралт

**ӨРХ, СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙГ ХАРИУЦАН АЖИЛЛАХ
 МЭРГЭЖИЛТЭН, ЭХ БАРИХ, ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭМЧ НАРЫН ХУВААРЬ**


| № | Эрүүл мэндийн байгууллага | Эрүүл мэндийн газрын мэргэжилтэн | Эх барих, эмэгтэйчүүдийн эмч |
|----|---------------------------|----------------------------------|---|
| 1 | Баян-Агт сумын ЭМТ | П.Отгонбаяр Утас:99903877 | Аймгийн Нэгдсэн эмнэлгийн Төрөх эмэгтэйчүүдийн тасгийн их эмч Б.Цогтгэрэл (Зөвлөх зэрэгтэй) Утас:99349677 |
| 2 | Тэшиг сумын ЭМТ | С.Ариунаа Утас:99173919 | |
| 3 | Хутаг-Өндөр сумын ЭМТ | Э.Халиун Утас:99076551 | |
| 4 | Сайхан сумын ЭМТ | Ө.Баасансүрэн Утас:95793999 | Аймгийн Нэгдсэн эмнэлгийн Төрөх эмэгтэйчүүдийн их эмч Р.Одгарам (Тэргүүлэх зэрэгтэй) Утас:99239209 |
| 5 | Дашинчилэн сумын ЭМТ | П.Мягмарсүрэн Утас:99409164 | |
| 6 | Хишиг-Өндөр сумын ЭМТ | С.Батхишиг Утас: 95766899 | |
| 7 | Орхон сумын ЭМТ | Л. Мөнхзул Утас:99773741 | Аймгийн Нэгдсэн эмнэлгийн Төрөх эмэгтэйчүүдийн тасгийн их эмч Б.Үүрийнтуяа Утас:99949777 |
| 8 | Могод сумын ЭМТ | Д.Нарантуяа Утас:99692354 | |
| 9 | “Эмийн цэцэглэн” ӨЭМТ | А.Оюунжаргал Утас:86026808 | |
| 10 | “Цоожэд” ӨЭМТ | А.Оюунжаргал Утас:86026808 | Аймгийн Нэгдсэн эмнэлгийн Төрөх эмэгтэйчүүдийн тасгийн их эмч Ц.Азжаргал Утас:99810294 |
| 11 | Гурванбулаг сумын ЭМТ | Г.Байгальмаа Утас:95966866 | |
| 12 | Бүрэгхангай сумын ЭМТ | Б.Батцэцэг Утас:99349289 | |
| 13 | Рашаант сумын ЭМТ | Ж.Гүндэгмаа Утас:99451487 | Аймгийн Нэгдсэн эмнэлгийн Төрөх эмэгтэйчүүдийн тасгийн их эмч Э.Нямдаваа Утас:88190011 |
| 14 | Баяннуур сумын ЭМТ | Б.Гантулга Утас:99442404 | |
| 15 | Бугат сумын ЭМТ | В.Урангаваа Утас:99354952 | |
| 16 | Сэлэнгэ сумын ЭМТ | О.Эрдэнэцэцэг Утас:99811896 | Аймгийн Нэгдсэн эмнэлгийн Төрөх, эмэгтэйчүүдийн тасгийн нярайн их эмч П.Оюун-Эрдэнэ |
| 17 | Хангал сумын ЭМТ | Д.Батдэлгэр Утас: 99312692 | |
| 18 | Хянганд сумын ЭМТ | Бат-Өлзий | |

Эрүүл мэндийн газрын даргын 2022 оны
01 дугаар сарын 20 -ны өдрийн 104
дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралт

**ӨРХ, СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙГ ХАРИУЦАН АЖИЛЛАХ
ХҮҮХДИЙН ЭМЧ НАРЫН ХУВААРЬ**

| № | Эрүүл мэндийн байгууллага | Хүүхдийн эмч |
|----|---------------------------|---|
| 1 | Баян-Агт сумын ЭМТ | Аймгийн Нэгдсэн эмнэлгийн Төрөх эмэгтэйчүүдийн их эмч Р.Одгарам (Ахлах зэрэгтэй) Утас:99239209 |
| 2 | Тэшиг сумын ЭМТ | |
| 3 | Хутаг-Өндөр сумын ЭМТ | |
| 4 | Сайхан сумын ЭМТ | |
| 5 | Дашинчилэн сумын ЭМТ | Аймгийн Нэгдсэн эмнэлгийн Амбулаторын тасгийн хүүхдийн их эмч С.Энхмаа Утас-99255031 |
| 6 | Хишиг-Өндөр сумын ЭМТ | |
| 7 | Орхон сумын ЭМТ | |
| 8 | Могод сумын ЭМТ | |
| 9 | “Эмийн цэцэглэн” ӨЭМТ | Аймгийн Нэгдсэн эмнэлгийн Хүүхдийн тасгийн эрхлэгч, их эмч Х.Энхцэцэг (Тэргүүлэх зэрэгтэй) Утас:99349604 |
| 10 | “Цоожэд” ӨЭМТ | |
| 11 | Гурванбулаг сумын ЭМТ | |
| 12 | Бүрэгхангай сумын ЭМТ | |
| 13 | Рашаант сумын ЭМТ | |
| 14 | Баяннуур сумын ЭМТ | Аймгийн Нэгдсэн эмнэлгийн Хүүхдийн тасгийн хүүхдийн их эмч Б.Сарантуяа (Тэргүүлэх зэрэгтэй) Утас:9914977 |
| 15 | Бугат сумын ЭМТ | |
| 16 | Сэлэнгэ сумын ЭМТ | |
| 17 | Хангал сумын ЭМТ | |
| 18 | Хялганат тосгоны ЭМТ | |

Эрүүл мэндийн газрын даргын 2022 оны
07 дугаар сарын 20-ны өдрийн А/04
 дугаар тушаалын тавдугаар хавсралт



**БОДЛОГЫН БИЧИГ БАРИМТ, СТАНДАРТ, УДИРДАМЖ, ТУШААЛЫН
 ХЭРЭГЖИЛТИЙГ ҮНЭЛЭХ ХУУДАС**

| № | Бодлогын бичиг баримтын нэр | Биелэлт гаргах чиглэл | Үнэлгээ | | | | |
|---|---|---|---------|---|---|---|---|
| | | | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | Засгийн газрын 2017 оны 78 дугаар тогтоолоор батлагдсан “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” үндэсний хөтөлбөр | Хөтөлбөр хэрэгжүүлэх төлөвлөгөө батлагдсан эсэх | | | | | |
| | | Хөтөлбөр хэрэгжүүлэх талаар гаргасан тушаал буй эсэх | | | | | |
| | | Төлөвлөгөөний хэрэгжилт байгаа эсэх | | | | | |
| 2 | ЭМС-ын 2021 оны А/392 дугаар “Коронавируст халдвар (Ковид-19)-ын үед жирэмсэн, төрөх, төрсний дараа үзүүлэх тусламж, үйлчилгээний түр зааврыг шинэчлэн батлах тухай” тушаал | Тушаалыг хэрэгжүүлэх талаар гаргасан тушаал шийдвэрүүд буй эсэх | | | | | |
| | | Тушаалын хэрэгжилтэнд дотоодын хяналт үнэлгээ хийсэн эсэх | | | | | |
| 3 | ЭМС-ын 2020 оны А/318 дугаар “Жирэмсэн, төрөх, төрсний дараах үед үзүүлэх тусламж, үйлчилгээний журам” тушаал | Тушаал, журмыг хэрэгжүүлэх талаар гаргасан тушаал шийдвэрүүд буй эсэх | | | | | |
| | | Сургалт хийсэн эсэх | | | | | |
| | | Тушаалын хэрэгжилт байгаа эсэх | | | | | |
| 4 | ЭМС-ын 2019 оны А/614 дугаар “Эхээс хүүхдэд ХДХВ, В-гепатит, Тэмбүү халвдар дамжих зогсоох тухай” тушаал | Тушаал, журмыг хэрэгжүүлэх талаар гаргасан тушаал шийдвэрүүд буй эсэх | | | | | |
| | | Сургалт хийсэн эсэх | | | | | |
| | | Тушаалын хэрэгжилтэнд дотоодын хяналт үнэлгээ хийсэн эсэх | | | | | |
| 5 | ЭМС-ын 2021 оны А/133 дугаар “Коронавируст халдвар (Ковид-19)-ын үед жирэмснийг хянах цахим үзлэгийн түр журам” тушаал | Тушаалыг хэрэгжүүлэх талаар гаргасан шийдвэрүүд хэрэгжиж буй эсэх | | | | | |
| | | Сургалт хийсэн эсэх | | | | | |
| | | Тушаалын хэрэгжилтэнд дотоодын хяналт үнэлгээ | | | | | |

| | | | | | | | |
|-----------------|--|--|--|--|--|--|--|
| 6 | ЭМС-ын 2018 оны А/545 дугаар “Нярайд үзүүлэх эмнэлгийн тусламж үйлчилгээний заавар” тушаал | Эх, нярайн тусламжийн хяналтын хуудас ашиглан хяналт хийсэн эсэх | | | | | |
| | | Хяналтын дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээ байгаа эсэх | | | | | |
| | | Сургалт хийсэн эсэх | | | | | |
| 7 | Хүүхдийн өвчний цогц менежментийн удирдамж | ХӨЦМ хэрэгжүүлэх талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ байгаа эсэх | | | | | |
| | | Сургалт хийсэн эсэх | | | | | |
| | | Хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, үр дүн | | | | | |
| Нийт авсан оноо | | | | | | | |

Авбал зохих оноо- 7 /тийм бол-1, үгүй бол-0/

Эрүүл мэндийн байгууллагууд авбал зохих онооноос:

- 5-7 оноо авсан бол “А”
- 3-4 оноо авсан бол “С”
- 0 -2 ба түүнээс доош оноо авбал “F” буюу хангалтгүйд тооцно.

Жич: 2 буюу түүнээс дээш хяналтын хуудсанд “D”, “F” үнэлгээ авсан тохиолдолд тухайн ЭМБ-ын үйл ажиллагааг “Хангалтгүй”-д тооцож, жилийн эцсийн ажил дүгнэх шалгуур үзүүлэлтэнд оруулах болно.

ЖИРЭМСЛЭХЭЭС ӨМНӨХ ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭГ ҮНЭЛЭХ ХУУДАС

| № | Үзүүлэлт | Үнэлгээ | | | | |
|---|--|---------|---|---|---|---|
| | | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | Харьяаллын нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн бүртгэл, судалгааг гаргасан эсэх | | | | | |
| 2 | Өсвөр насны охидод урьдчилан сэргийлэх үзлэг хийж, эрүүлжүүлэн тусламж, үйлчилгээ үзүүлсэн эсэх | | | | | |
| 3 | Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, эсэн мэнд амаржихуйн чиглэлээр эрүүл мэндийн боловсрол олгосон эсэх | | | | | |
| 4 | Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, эрүүлжүүлэх арга хэмжээ авсан эсэх | | | | | |
| 5 | Жирэмслэлтэд бэлтгэх зөвлөгөө өгч, тусламж үзүүлсэн эсэх | | | | | |
| 6 | Гэр бүл төлөвлөлтийн тусламж үйлчилгээ үзүүлсэн эсэх | | | | | |
| | Нийт авсан оноо | | | | | |

Авбал зохих оноо-6 /Тийм бол-1, үгүй бол-0/

Эрүүл мэндийн байгууллагууд авбал зохих онооноос:

- 5-6 оноо авсан бол "А"
- 3-4 оноо авсан бол "В"
- 1-2 оноо авсан бол "D"
- 0 оноо авсан бол "F"

ЖИРЭМСЭН ҮЕИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭГ ҮНЭЛЭХ ХУУДАС

| № | Үзүүлэлт | Үнэлгээ | | | | |
|----|---|---------|---|---|---|---|
| | | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | Жирэмсэнг баталгаажуулж /хэт авианы шинжилгээ, жирэмсний сорил/ оношилсон эсэх | | | | | |
| 2 | Жирэмсний 12 долоо хоногийн дотор хяналтанд орсон эсэх | | | | | |
| 3 | Жирэмсний хугацаанд 6 ба түүнээс дээш удаа хяналтанд орсон эсэх | | | | | |
| 4 | Төмрийн бэлдмэл, фолийн хүчлийг жирэмсний турш уухыг зөвлөсөн эсэх | | | | | |
| 5 | ХДХВ, ДОХ-ын сорил хийсэн эсэх | | | | | |
| 6 | Тэмбүүгийн сорил хийсэн эсэх | | | | | |
| 7 | Цусны гемоглобин үзсэн эсэх | | | | | |
| 8 | Шээсэнд уураг үзсэн эсэх | | | | | |
| 9 | Хэт авиан шинжилгээ хийсэн эсэх | | | | | |
| 10 | Флюорографийн шинжилгээ хийсэн эсэх | | | | | |
| 11 | Үтрээний наацын шинжилгээ хийсэн эсэх | | | | | |
| 12 | Резус хүчин зүйл тодорхойлсон эсэх | | | | | |
| 13 | Цусны бүлэг тодорхойлсон эсэх | | | | | |
| 14 | Жирэмсэн үеийн толины үзлэг хийсэн эсэх | | | | | |
| 15 | Жирэмсний өртөмтгий байдлын илрүүлэлт: анх, 20,28, 32, 36 долоо хоногтойд илрүүлсэн эсэх | | | | | |
| 16 | Эхээс хүүхдэд ХДХВ, гепатитийн В вирус, тэмбүүгийн халдвар дамжихыг таслан зогсоосон эсэх | | | | | |
| 17 | Жирэмсний өндөр эрсдлийг үнэлж илрүүлсэн эсэх | | | | | |
| 18 | Өндөр эрсдэлтэй жирэмсэн эмэгтэйг хянасан эсэх | | | | | |
| 19 | Зөвлөгөө өгсөн эсэх | | | | | |
| 20 | Шаардлагатай тохиолдолд хэвтүүлэн эмчилсэн эсэх | | | | | |
| 21 | Жирэмсний хүндрэлийн үед шилжүүлэхээс өмнөх тусламж авсан эсэх | | | | | |
| 22 | Жирэмсний хүндрэлийн үеийн эмчилгээ хийлгэсэн эсэх | | | | | |
| 23 | Өндөр эрсдэлтэй жирэмсэн эмэгтэйг дараагийн шатлалын эмнэлэгт шилжүүлсэн эсэх | | | | | |
| | Нийт авсан оноо | | | | | |

Авбал зохих оноо-23 /тийм бол-1, үгүй бол-0/

Эрүүл мэндийн байгууллагууд авбал зохих онооноос:

- 20-23 оноо авсан бол “А”
- 16-19 оноо авсан бол “В”
- 12-15 оноо авсан бол “С”
- 8-11 оноо авсан бол “D”

ТӨРСНИЙ ДАРААХ ҮЕИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭГ ҮНЭЛЭХ ХУУДАС

| № | Үзүүлэлт | Үнэлгээ | | | | |
|---|---|---------|---|---|---|---|
| | | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | Төрсөн эхийн мэдээллийг төрсний дараах 24 цагийн дотор солилцсон эсэх | | | | | |
| 2 | Эх, нярайг гэрээр товллын дагуу эргэж, үзлэг хийж, зөвлөгөө өгсөн эсэх | | | | | |
| 3 | Шаардлагатай тохиолдолд хэвтүүлэн эмчилсэн эсэх | | | | | |
| 4 | Гэр бүл төлөвлөлтийн талаар зөвлөгөө өгч, үйлчлүүлэгчид сонголт хийхэд дэмжлэг үзүүлж, тусламж үйлчилгээг үзүүлсэн эсэх | | | | | |
| | Нийт авсан оноо | | | | | |

Авбал зохих оноо-4 /Тийм бол-1, үгүй бол-0/

Эрүүл мэндийн байгууллагууд авбал зохих онооноос:

- 4 оноо авсан бол "А"
- 3 оноо авсан бол "В"
- 2 оноо авсан бол "С"
- 1 оноо авсан бол "D"
- 0 оноо авсан бол "F"

“ХӨЦМ”-ИЙН ХЭРЭГЖИЛТИЙН БАЙДЛЫГ ШАЛГАХ ХЯНАЛТЫН ХУУДАС

| № | Асуумж | Үнэлгээ | | | | |
|----|--|----------------|---|---|---|---|
| | | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | ХӨЦМ-ийн хүснэгтэн товхимол байгаа эсэх | | | | | |
| 2 | ХӨЦМ-ийн ханын хүснэгт байгаа эсэх | | | | | |
| 3 | ХӨЦМ-ийн үзлэгийн маягт байгаа эсэх | | | | | |
| 4 | Эх хүүхдийн эрүүл мэндийн дэвтрийн нөөц байгаа эсэх | | | | | |
| 5 | Өсөлтийн мэдээ хөтөлдөг эсэх | | | | | |
| 6 | Хүүхэд үнэлэхэд шаардлагатай хангамж (ус, аяга, халбага) байгаа эсэх | | | | | |
| 7 | Ажиллаж байгаа ШСЭБ байгаа эсэх | | | | | |
| 8 | ШСЭБ-ийн бүртгэл байгаа эсэх | | | | | |
| 9 | Өвчтөнийг жинлэдэг, халууныг нь хэмждэг эсэх | | | | | |
| 10 | Өвчнийг нь үнэлж ангилдаг эсэх | | | | | |
| 11 | Эмнэлэгт хэвтүүлэлтийг шийддэг эсэх | | | | | |
| 12 | Хөхөөр хооллолт ба хооллолтын бэрхшээлийг үнэлдэг эсэх | | | | | |
| 13 | Хооллолтын талаар зөвлөдөг эсэх | | | | | |
| 14 | Эм бичиж өгдөг эсэх | | | | | |
| 15 | Эмнэлэгт ШСД-ны уусмал өгдөг эсэх | | | | | |
| 16 | ШСД-ны уусламыг гэртээ яаж өгөх төлөөр зөвлөдөг эсэх | | | | | |
| 17 | Эмийн эхний тунг өгдөг эсэх | | | | | |
| 18 | Эм яаж уухыг заадаг эсэх | | | | | |
| 19 | Уушигны хатгалгаанд | Амоксициллин | | | | |
| | | Эритромицин | | | | |
| 20 | Цусан суулгалтанд | Ципрофлоксацин | | | | |
| | | Тетрациклин | | | | |
| 21 | Гентамицин байгаа эсэх | | | | | |
| 22 | Парацетомол байгаа эсэх | | | | | |
| 23 | Тетрациклины нүдний тос байгаа эсэх | | | | | |
| 24 | А аминдэм байгаа эсэх | | | | | |
| 25 | Д аминдэм байгаа эсэх | | | | | |
| 26 | Шингэн сэлбэх давс байгаа эсэх | | | | | |
| 27 | Шингэн их алдалтанд судсаар сэлбэх шингэнүүд байгаа эсэх | | | | | |
| | Нийт авсан оноо | | | | | |

Авбал зохих оноо – 27 /тийм бол-1, үгүй бол-0/

Эрүүл мэндийн байгууллагууд авбал зохих онооноос:

- 26-27 оноо авсан бол “А”
- 23-25 оноо авсан бол “В”
- 20-22 оноо авсан бол “С”
- 17-19 оноо авсан бол “D”

ТӨРӨЛТИЙН ТҮҮХ БИЧИЛТИЙГ ШАЛГАХ ХЯНАЛТЫН ХУУДАС

| № | Үзүүлэлт | Үнэлгээ | | | | |
|----|--|---------|---|---|---|---|
| | | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | Паспортын хэсэг бүрэн бөглөгдсөн эсэх | | | | | |
| 2 | Халууны хуудас бүрэн бөглөгдсөн эсэх | | | | | |
| 3 | Эмчилгээний хуудас бүрэн бөглөгдсөн эсэх | | | | | |
| 4 | Цусны бүлэг үзэж, тэмдэглэсэн эсэх | | | | | |
| 5 | Цусны резус бүлэг үзэж тэмдэглэсэн эсэх | | | | | |
| 6 | Төрөлтийн анамнезийг хангалттай цуглуулсан эсэх | | | | | |
| 7 | Амьдралын анамнезийг бүрэн цуглуулсан эсэх | | | | | |
| 8 | Эхийн биеийн байдлыг зөв үнэлж тэмдэглэсэн эсэх | | | | | |
| 9 | Эхийн зовиур, шинж тэмдэгийг сайн тэмдэглэсэн эсэх | | | | | |
| 10 | Ерөнхий үзлэгийг бүрэн хийж тэмдэглэсэн эсэх | | | | | |
| 11 | Эх барихын тусгайлсан үзлэг (гадуур, дотуур)-ийг бүрэн хийж тэмдэглэсэн эсэх | | | | | |
| 12 | Онош бүрэн тавигдсан эсэх | | | | | |
| 13 | Онош тавихдаа оношийн үндэслэлийг бүрэн гаргасан эсэх | | | | | |
| 14 | Клиникийн оношийг 3 хоногийн хугацаанд тавьсан эсэх | | | | | |
| 15 | Эмчилгээ бичихдээ эмгэг жамын дарааллыг баримталсан эсэх | | | | | |
| 16 | Эмийн тун хэмжээг стандарт заасан хэмжээнд бичсэн эсэх | | | | | |
| 17 | Төрөлтийн төлөвлөгөө хийгдсэн эсэх | | | | | |
| 18 | Ажилбарын үед гарын үсэг зуруулж зөвшөөрөл авсан эсэх | | | | | |
| 19 | Партограмм хөтлөгдсөн эсэх | | | | | |
| 20 | Зөвлөх эмч, тасгийн эрхлэгчийн тойрон үзлэг хийгдэж тэмдэглэсэн эсэх | | | | | |
| 21 | Явцын болон үечилсэн эпикризийг заагдсан хугацаа тохиолдолд бичсэн эсэх | | | | | |
| 22 | Шаардлагатай тохиолдолд шилжүүлэх эпикризийг бичсэн эсэх | | | | | |
| 23 | Гарах үеийн эпикризийг бүрэн бичсэн эсэх | | | | | |
| 24 | Өвчний түүхийг нэг өнгийн бэхээр цэвэр ойлгомжтой бичсэн эсэх | | | | | |
| | Нийт авсан оноо | | | | | |

Авбал зохих оноо – 24 /тийм бол-1, үгүй бол-0/

Эрүүл мэндийн байгууллагууд авбал зохих онооноос:

- 22-24 оноо авсан бол “А”
- 19-21 оноо авсан бол “В”
- 16-18 оноо авсан бол “С”
- 13-15 оноо авсан бол “D”

ЭХ, НЯРАЙН ГЭРИЙН ЭРГЭЛТИЙН БАЙДЛЫГ ШАЛГАХ ХЯНАЛТЫН ХУУДАС

| № | Зорилтот алхам | Үнэлгээ | | | | |
|-------------------------|--|---------|---|---|---|---|
| | | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| Анамнезийн хэсэг | | | | | | |
| 1 | Төрсөн огноо | | | | | |
| 2 | Амаржих газраас гарсан огноо | | | | | |
| 3 | Төрөлтийн анамнезийг бүрэн цуглуулсан байдал | | | | | |
| 4 | Хүүхэд дутуу/гүйцэт, бүтэлттэй/бүтэлттгүй төрсөн Апгарын онооны талаар тэмдэглэсэн эсэх | | | | | |
| 5 | Солилцох хуудас дээр эхийн онош бүрэн тавигдсан эсэх | | | | | |
| 6 | Хүүхдийн онош бүрэн тавигдсан эсэх | | | | | |
| 7 | Анхны дархжуулалт хийгдсэн | | | | | |
| Нярайн үзлэг | | | | | | |
| 8 | Уйлалт | | | | | |
| 9 | Хөдөлгөөний идэвхи | | | | | |
| 10 | Булчингийн хүчдэл | | | | | |
| 11 | Физиологийн рефлекс | | | | | |
| 12 | Зулай, заадас гавлын байдал | | | | | |
| 13 | Арьс (шарлалт) | | | | | |
| 14 | Зүрх судас | | | | | |
| 15 | Амьсгалын тоо 1 минутанд | | | | | |
| 16 | Хүйний шарх | | | | | |
| 17 | Хэвлий | | | | | |
| 18 | Шээсний гарц | | | | | |
| 19 | Өтгөний байдал | | | | | |
| 20 | Дүгнэлт | | | | | |
| 21 | Эмчийн гарын үсэг | | | | | |
| Эхийн үзлэг | | | | | | |
| 22 | Зовиур | | | | | |
| 23 | Биеийн халуун | | | | | |
| 24 | Арьс, салстын өнгө | | | | | |
| 25 | Нүдний зовхи | | | | | |
| 26 | Судасны цохилт тоолсон | | | | | |
| 27 | Артерийн даралт 2 гарт үзсэн | | | | | |
| 28 | Амьсгал тоолсон /1 минутанд/ | | | | | |
| 29 | Хэлний өнгөр | | | | | |
| 30 | Хэвлий | | | | | |
| 31 | Умайн агшилт | | | | | |
| 32 | Шавхарга (өнгө, хэмжээ, үнэр) | | | | | |
| 33 | Төрөх замын шархыг үзсэн | | | | | |
| 34 | Кесар хагалгааны шархыг үзсэн | | | | | |
| 35 | Хаван | | | | | |
| 36 | Шээсний гарц | | | | | |
| 37 | Өтгөний байдал | | | | | |

| | | | | | | |
|------------------------------|---|--|--|--|--|--|
| 39 | Эмчийн гарын үсэг | | | | | |
| Зөвлөгөө өгсөн байдал | | | | | | |
| 40 | Хөхөөр хооллолт | | | | | |
| 41 | Төрсний дараах эрүүл ахуй | | | | | |
| 42 | Нярайн асаргаа сувилгаа | | | | | |
| 43 | Төрсний дараах аюултай шинжүүд | | | | | |
| 44 | Нярайн аюултай шинжүүд | | | | | |
| 45 | Гэр бүл төлөвлөлт | | | | | |
| 46 | Зөвлөгөө өгсөн тухай тэмдэглэл хөтөлсөн | | | | | |
| | Нийт авсан оноо | | | | | |

Авбал зохих оноо – 46 /тийм бол-1, үгүй бол-0/

Эрүүл мэндийн байгууллагууд авбал зохих онооноос:

- 45-46 оноо авсан бол “А”
- 42-44 оноо авсан бол “В”
- 39-41 оноо авсан бол “С”
- 36-38 оноо авсан бол “D”
- 35 ба түүнээс доош оноо авбал “F” буюу хангалтгүйд тооцно.

ХҮҮХДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАЛААР АСУУМЖ, ЯРИЛЦЛАГА

/Сум, өрхийн Эрүүл мэндийн төвийн 0-1 насны хүүхэдтэй эхчүүдээс авна/

| № | Асуумж | Хариулт |
|----|---|---|
| 1 | Төрсний дараа нярайг нүцгэнээр таны цээжин дээр байлгасан уу | |
| 2 | Төрсний дараа 30 минутаас цагийн дотор амлуулсан уу | |
| 3 | Нярайг төрсний дараа хэдэн цагийн дараа угаасан вэ | |
| 4 | Нярайг төрмөгц нь малгай өмсүүлсэн үү | |
| 5 | Төрөхөөс гарснаас хойш хэд хоногийн дараа эмч гэрт ирж үзсэн бэ | 1. 3 хоног /1 оноо/ 2. 7 хоног /1 оноо/ 3. Огт үзээгүй /0 оноо/ |
| 6 | Нярайг 2 сар хүртэл нь эмч хэдэн удаа гэрт ирж үзсэн бэ | 1. 7 хоног бүр /1/ 2. Сард 1 удаа /0/ 3. Дуудсан үед /0/ |
| 7 | Сар бүр хүүхдийн жин өндрийг үздэг үү | |
| 8 | Хүүхдийн нэмэлт хоолны талаар зөвлөгөө өгдөг үү | |
| 9 | Таны хүүхэд аминдэм А уусан уу | |
| 10 | Таны хүүхэд аминдэм Д уусан уу | |
| 11 | Олон найрлагат бичил тэжээлийн бэлдмэл уусан уу | |
| 12 | Эх хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр бий юу | |
| 13 | Таны хүүхдэд вакцин хийсэн үү | 1. Төрсний дараа 2. 2,3,4,9 сартайд |
| 14 | Хүүхдэд вакцин хийхээс өмнө эмч үзсэн үү | |
| 15 | Вакцины ач холбогдлын талаар эмч зөвлөгөө өгсөн үү | |
| 16 | Төрсний дараа гэрт нярайг эргэлтээр үзэхдээ таныг үзсэн үү | |
| 17 | Танд гэр бүл төлөвлөлтийн талаар зөвлөгөө өгсөн үү | |
| 18 | Жирэмснээс сэргийлэх ямар нэгэн арга хэрэглэж байгаа юу | |
| | Нийт авсан оноо | |

Авбал зохих оноо-18 /тийм бол-1, үгүй бол-0/

Эрүүл мэндийн байгууллагууд авбал зохих онооноос:

- 17-18 оноо авсан бол "А"
- 15-16 оноо авсан бол "В"
- 13-14 оноо авсан бол "С"
- 11-12 оноо авсан бол "D"
- 10 ба түүнээс доош оноо авбал "F" буюу хангалтгүйд тооцно.

**ЖИРЭМСНИЙ ӨМНӨХ, ЖИРЭМСЭН, ТӨРСНИЙ ДАРААХ ҮЕД ҮЗҮҮЛЭХ
ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛ**

| | Тусламж үйлчилгээ |
|----------------------------------|---|
| 1.Жирэмслэхээс өмнө | <ul style="list-style-type: none"> • Үйлчлэх хүрээний нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн бүртгэл, судалгаа хийнэ. • Үйлчлэх хүрээний хөгжлийн бэрхшээлтэй, хөдөлмөрийн чадвар түр алдалттай нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн судалгааг гаргаж, гэр бүл төлөвлөлтийн тусламж, үйлчилгээ үзүүлнэ. • Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийг жил бүр эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, эрүүл мэндийн бүлгээр ангилан эмчлэн, эрүүлжүүлж, гэр бүл төлөвлөлтийн тусламж, үйлчилгээ үзүүлнэ. • Жирэмсэлтэд бэлтгэх зөвлөгөө өгч, тусламж үзүүлнэ. • БНҮЭМ, эсэн мэнд амаржихуйн чиглэлээр эрүүл мэндийн боловсрол олгоно. |
| 2.Жирэмсэн эхийн асуумж, өгүүлэл | <p>Жирэмсний эхний үзлэг <u>Асуумж авах</u></p> <ul style="list-style-type: none"> • Одоогийн жирэмсэнтэй холбоотой • Өмнөх жирэмсэн, төрөлтийн талаарх мэдээлэл • Эрүүл мэндийн дурьдатгал • Нийгмийн байдал • Ажлын нөхцөл • Хүчирхийлэл <p><i>Өндөр эрсдлийг илрүүлэх жирэмсний хугацаа о</i> Жирэмсэн эмэгтэйг анх хяналтад авахад о</p> <ul style="list-style-type: none"> • 20 долоо хоногтой • 28 долоо хоногтой • 36 долоо хоногтой |
| 3.Жирэмсэн үеийн үзлэг | <p>Жирэмсэн эмэгтэйн хяналтын эхний үзлэгийг заавал их эмч хийнэ <i>Жирэмсэн эмэгтэйд зайлшгүй хийгдэх үзлэг</i></p> <ul style="list-style-type: none"> • Ерөнхий биеийн үзлэг хийх, • Артерийн даралтыг 2 гарт үзэх, • Судасны лугшилтыг тоолох, о Биеийн жин, өндөрийг хэмжих, • Хөхний үзлэг хийх, • Умайн ёроолын өндөр хэмжих, • Хэвлийн тойрог хэмжих, • Эх барихын гадуур үзлэг хийх, • Ургийн зүрхний цохилт чагнах, • Үтрээний үзлэг хийх |

| | |
|---|--|
| <p>4.Жирэмсэн эмэгтэйд хийгдэх сорил, шинжилгээ</p> | <p><u>Өрх, сум,тосгоны ЭМТ-д:</u></p> <ul style="list-style-type: none"> • Жирэмсний сорил • Цусны бүлэг • Резус бүлэг тодорхойлох • Тэмбүү илрүүлэх хурдавчилсан арга • ХДХВ-ын эсрэг бие илрүүлэх хурдавчилсан арга • Элэгний В, С вирус илрүүлэх • Шээсэнд уураг илрүүлэх • Шээсэнд сахар үзэх, • Цусанд гемоглобины хэмжээ тодорхойлох <p><u>Шинжилгээ:</u></p> <ul style="list-style-type: none"> • Цусны ерөнхий шинжилгээ • Шээсний ерөнхий шинжилгээ • Тэмбүү илрүүлэх ийлдэс судлалын шинжилгээ (хурдавчилсан аргаар эерэг гарсан үед онош баталгаажуулах) • ХДХВ-ийн эсрэг бие илрүүлэх шинжилгээ(хурдавчилсан аргаар эерэг гарсан үед онош баталгаажуулах) • Үтрээ, умайн хүзүүний наацын (нойтон түрхэц) шинжилгээ • Шээсэнд нян илрүүлэх • Хэт авиан шинжилгээ • Ургийн зүрхний бичлэг (заалтаар) • Рентген шинжилгээ (заалтаар) • Биохимийн шинжилгээ (заалтаар) • Цусны дэлгэрэнгүй шинжилгээ (заалтаар) • Умайн хүзүүний эсийн шинжилгээ (заалтаар) • “ТоКСН” халдварыг илрүүлэх (заалтаар) • Стрептококкийн халдварыг үзэх (заалтаар) • Пренатал илрүүлэг (заалтаар) • Пренатал оношилгоо (заалтаар) |
| <p>5.Жирэмсэн үеийн зөвлөгөө, мэдээлэл</p> | <p><u>Зөвлөгөөний сэдэв:</u></p> <ul style="list-style-type: none"> • Жирэмсний хяналтын ач холбогдол • Жирэмсэн эмэгтэй өөрийгөө хэрхэн хянах тухай • Амны хөндийн эрүүл мэнд • Жирэмсэн үеийн хоол • Хорт зуршил.архи тамхины хор, дам тамхидалтаас сэргийлэх • Бэлгийн замаар дамжих халдвараас сэргийлэх • Жирэмсний эмгэг байдал /аюултай шинжүүд • Төмрийн бэлдмэл. фолийн хвчил. бичил |

| | |
|---|--|
| | <ul style="list-style-type: none"> • Зулбалт, дутуу төрөлтөөс сэргийлэх • Цус багадалтын тухай • Эрхтэн тогтолцооны эмгэгийн талаар • Төрөлтийн тухай /төрлөг эхлэх шинж/ • Жирэмсний хожуу хордлогын тухай • Хөх арчлах тухай |
| | <ul style="list-style-type: none"> • Төрөлтөд бэлтгэх • Хүчирхийллээс ангид байх • Эхээс хүүхдэд дамжих халдвар /ХДХВ/ДОХ, Тэмбүү, гепатитийн В вирус/, • Сэтгэл зүйн бэлтгэл • Илүү тээлтийн тухай • Төрөх үеийн өвдөлтийг бууруулах аргууд • Төрсний дараа үе • Нярайн эрт үеийн нэн шаардлагатай тусламж /асаргаа, сувилгаа, дулаан алдалтаас сэргийлэх, • Дутуу нярайн “Имж- эх” асаргаа • Гэр бүл төлөвлөлт <p>Халдварт өвчин илэрсэн бол холбогдох зөвлөгөөг өгөх</p> |
| | <p>Зайлшгүй өгөх мэдээлэл:</p> <ul style="list-style-type: none"> • Жирэмсэлт, төрөлттэй холбоотой хууль эрхзүйн ойлголт • Эмийн аюулгүй хэрэглээ • Жирэмсэн үеийн хувцаслалт • Жирэмсний дасгал хөдөлгөөн • Хэт авиан шинжилгээг хийх хугацаа • Ургийн хөдөлгөөнийг хянах тухай • Даруулга хэрэглэхийн ач холбогдол • Жирэмсэн үед аялах /агаарын тээврээр зорчих, жолоо барих/ • Төрлөгийн үеийн туслагч • Кесар мэс заслын талаарх ойлголт • Хүүхдээ эрт амлуулах, эхийн сүүгээр хооллох • Гэр бүлийн оролцоог дэмжих • Пренатал илрүүлэг, оношилгооны тухай • Эх, хүүхдийн эрүүл мэндийн дэвтрийн тухай • Төрсний дараах үзлэг, гэрийн эргэлтийн талаар |
| <p>6. Жирэмсний хяналтын явцад хийгдэх бусад тусламж, үйлчилгээ</p> | <ul style="list-style-type: none"> • Жирэмсний хугацаа болон төрөх хугацааг тодорхойлно. • Үзлэгийн явцад илрүүлсэн асуудлуудыг эхэд таниулна. |

| | |
|--|---|
| | <ul style="list-style-type: none">• Хяналтын дараагийн хугацааг товлони.• Эхийг эрүүлжүүлэх төлөвлөгөө гаргана.• Жирэмсэн эмэгтэй бүрт төмөр, фолийн хүчлын бэлдмэлийг сэргийлэх тунгаар хэрэглэхийг зөвлөнө.• Заалтаар кальцийн бэлдмэл уулгана.• Шаардлагатай нэмэлт шинжилгээ, үзлэгийг хийнэ.• Амаржих газрыг товлони. |
|--|---|

7.Төрсний дараах үеийн тусламж

Эхэд үзүүлэх тусламж

- Төрөлтийн талаар эх болон ар гэрийнхэнд мэдээлэл өгнө.
- Ерөнхий биеийн үзлэг хийнэ.
- Хүндрэлийг эрт илрүүлэх ба хүндрэлээс урьдчилан сэргийлнэ.(халдвар, цус алдалт, цус багадалт)

Зөвлөгөө

- Хооллолтын тухай
- Төрсний дараа илрэх аюултай шинжүүд (цус алдах, халуурах, толгой өвдөх, дотор муухайрах, хэвлийгээр өвдөх)
- Хөхний арчилгаа, эхийн сүүгээр хооллолт
- Нярайн асаргаа сувилгаа, нярайн аюултай шинж
- Аюулгүй бэлгийн харьцааны тухай
- Цус багадалтаас урьдчилан сэргийлэх, (төмөр.фолийн хүчлийн нэмэлт)
- Гэр бүл төлөвлөлт, төрсний дараа жирэмслэхээс хамгаалах тухай

Нярайн эрт үед үзүүлэх тусламж, үйлчилгээ

- Нярайг хуурайшуулна.
- Арьс арьсаар шүргэлцүүлнэ (Анхны тэврэлт).
- Нярайд малгай өмсгөнө.
- Хүйг зөв хугацаанд зөв хөндөнө.
- Ангир уургийг 1 цагийн дотор амлуулна.
- Нүдний сувилгаа хийнэ.
- Амндэм “К” нярайн булчинд тарина.
- Нярайн биеийн байдлыг үнэлэх, хянах, хүндрэлийг илрүүлж, эмчилнэ. (амьсгалын хямрал, халдвар, дутуу болон бага жинтэй нярай, гэмтэл, гажхөгжил гэх мэт)
- Нярайг 24 цагийн дотор усанд оруулахгүй.
- Төрсний дараах өрөөнд орох хүртэл эх, нярайг хамтад нь байлгаж, хянана

Амьдралын эхний 24 цагийн дотор В гепатит, БЦЖ, Саагийн эсрэг дархлаажуулалтыгхийнэ. (дархлаажуулалт хийхийн өмнө эхэд заавал хэлж, **Эх нярайд хамтад нь үзүүлэх тусламж**

- Төрсний дараах үзлэг, гэрийн эргэлт
- Төрсний дараа эх, нярайг үзнэ:
 - Эхний 24 цагийн дотор
 - Төрсний дараах 3 дахь хоног
 - Төрсний дараах 7 дахь хоногт заавал үзэж зохих тусламж үйлчилгээг үзүүлнэ.
 - Шаардлагатай тохиолдолд хугацаа харгалзахгүй үзнэ.

- Эх, нярайг төрсний дараах 5-6 дахь долоо

ЖИРЭМСЭН ЭМЭГТЭЙН ҮЗЛЭГ, ШИНЖИЛГЭЭНИЙ ТОВЛОЛ

| Үзлэгийн дугаар | Жирэмсний хугацаа | Үзлэгийн зорилго | Анхаарах зүйл |
|-----------------|-------------------------|--|--|
| 1 | 12 долоо хоногийн дотор | <ul style="list-style-type: none"> Асуумжийг бүрэн авна Үзлэгийг бүрэн хийнэ Жирэмсний хугацааг тодорхойлно. Жирэмсний өндөр эрсдлийг илрүүлнэ. Жирэмсэнг тээлгэх эсэх асуудлыг шийднэ. | Эхний үзлэгийг их эмч заавал хийнэ. Өндөр эрсдэлтэй жирэмсэн эмэгтэйг төрөлжсөн мэргэшлийн эмчид үзүүлж зөвлөөгөө авна, шаардлагатай тохиолдолд эх барих эмэгтэйчүүдийн эмчийн хяналтад шилжүүлнэ. |
| 2 | 20 долоо хоног | <ul style="list-style-type: none"> Жирэмсний өндөр эрсдлийг илрүүлнэ. Ургийн бүтэц болон ихэс, хүйн байдлыг шинжилнэ. | Солилцох хуудсыг олгоно. Жирэмсний явц хэвийн үед ч эх барих эмэгтэйчүүдийн мэргэжлийн эмчийн зөвлөгөө авна. |
| 3 | 24 долоо хоног | <ul style="list-style-type: none"> Жирэмсний явц, ургийн өсөлт хөгжилтийг хянанана. | |
| 4 | 28 долоо хоног | <ul style="list-style-type: none"> Жирэмсний явц, ургийн өсөлт хөгжилтийг хянанана. Жирэмсний өндөр эрсдлийг илрүүлнэ. | |
| 5 | 32 долоо хоног | <ul style="list-style-type: none"> Жирэмсний амралт олгоно. Сүрьеэ илрүүлэх асуумж авна. | Жирэмсний явц хэвийн үед ч эх барих эмэгтэйчүүдийн мэргэжлийн эмчийн зөвлөгөө авна. |
| 6 | 36 долоо хоног | <ul style="list-style-type: none"> Жирэмсний явц, ургийн өсөлт хөгжилтийг хянанана. Жирэмсний өндөр эрсдлийг илрүүлнэ. | Төрүүлэх газрыг товллоно. |
| 7 | 38 долоо хоног | <ul style="list-style-type: none"> Жирэмсний явц, ургийн өсөлт хөгжилтийг хянанана. | Төрөлтийн төлөвлөгөөг боловсруулна |
| 8 | 39-40 долоо хоног | <ul style="list-style-type: none"> Төрөлтөнд бэлтгэгдсэн байдлыг үнэлнэ Ургийн жинг тодорхойлно. | |

Тайлбар. Жирэмсний 41 долоо хомогт төрөөгүй бол жирэмсэн эмэгтэйг эмнэлэгт хэвтүүлж, төрүүлэх арга хэмжээ авна.

| Жирэмсний хугацаа | Хийгдэх шинжилгээ |
|--------------------------------|---|
| Анхны үзлэг | <ul style="list-style-type: none"> o Жирэмсний сорил o Цусны бүлэг o Резус бүлэг o ХДХВ-ын эсрэг бие илрүүлэх хурдавчилсан арга o Элэгний В, С вирус илрүүлэх o Тэмбүү илрүүлэх хурдавчилсан арга o Шээсний ерөнхий шинжилгээ o Үтрээ, умайн хүзүүний наацын (нойтон түрхэц) шинжилгээ o Хэт авиан шинжилгээ |
| 11-13 ^е долоо хоног | Эхний 3 сарын пренатал илрүүлэг (заалтаар) |
| 12-16 долоо хоног | Шээсэнд нян илрүүлэх |
| 16-20 долоо хоног | 2 дахь гурван сарын илрүүлэг (эхний илрүүлэг хийгдээгүй эсвэл заалтаар) |
| 18-22 долоо хоног | Ургийн бүтцийн хэт авиан шинжилгээ |
| 28 долоо хоног | Тэмбүүгийн сорил давтах |
| 32 долоо хоног | <ul style="list-style-type: none"> o Шээсний ерөнхий шинжилгээ o Үтрээ, умайн хүзүүний наацын (нойтон түрхэц) шинжилгээ o Хэт авиан шинжилгээ |